



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 09 сарын 24 өдөр

Дугаар А/419

Мандалговь

Үнэлгээний хорооны гишүүнээс чөлөөлж
нөхөн томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1, 47.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Үнэлгээний хорооны дарга М.Цогзолмаа нь эзлжийн амралттай, үнэлгээний хорооны гишүүн Р.Булгантамир нь шилжиж явсан тул Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжих "Өвлийн нарлаг хүлэмжийн цахилгаан хангамж, цэвэр усны ажил"-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны гишүүнээс чөлөөлсүгэй.

Хоёр. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжих "Өвлийн нарлаг хүлэмжийн цахилгаан хангамж, цэвэр усны ажил"-ын үнэлгээний хорооны даргаар Г.Самданцоодолыг буцаан томилж, гишүүнээр Ш.Бямба нарыг нөхөн томилсугай.

Гурав. Энэ захирамж гарсантай холбоотойгоор Аймгийн Засаг даргын 2018 оны 5 сарын 1-ний А/202 тоот захирамжийн хоёр дахь заалтын "Өвлийн нарлаг хүлэмжийн цахилгаан хангамж, цэвэр усны ажлын үнэлгээний хорооны даргаар М.Цогзолмааг нөхөн томилсугай" гэснийг хүчингүй болгосугай.

Дөрөв. Төндөр шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу шуурхай зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Г.Самданцоодол)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

438010326

